

<https://doi.org/10.69561/mjac.v25i48.3632>

Article | Fasc.16

“Шарилжин дундах цэцэг” үндэсний балетын судалгааны тойм

Гиймаагийн Барбаатар

Соёл урлагийн их сургуулийн Бүжгийн урлагийн сургууль, Улаанбаатар, Монгол Улс

ORCID: <https://orcid.org/0009-0004-1402-887X>

Холбоо барих зохиогч: baraag0917@gmail.com

Хураангуй: Монгол Улсад балетын урлаг үүсэж хөгжих үе шат нь 1944 оноос эхлэлтэй ба эдүгээ монгол үндэсний оюун сэтгэлгээ, ахуйн соёлыг тусгасан хорин дөрвөн үндэсний балетын урын сантай болсон. Монголын балетын урлагийн талаарх судалгааны материал бусад урлагийн салбарын судалгаатай харьцуулбал өнөө цагт цөөн байна. Түүнчлэн үндэсний нэг балетад хийсэн судалгааны тойм өгүүлэл хараахан хэвлэн нийтлэгдээгүй байна. Иймд 1958 оноос хойших бүжиг, театр судлаач нарын бичиж тэмдэглэсэн ном, шүүмж, өгүүллээс өнөөдрийн монголын балетын урлагийн түүхийг эргэн харах, судалгааны эргэлтэд оруулах шаардлагатай байна.

Энэхүү өгүүлэлд анхны үндэсний эмгэнэлт балет “Шарилжин дундах цэцэг”-ийн талаар бичсэн судалгааны бүтээлд анализ хийхийг зорив. Мөн тус өгүүллээс монголын балетын урлагийн тухай бичиж тэмдэглэсэн судлаачдын бүтээлийг нэг дороос цаг алдалгүй танин мэдэх, тэдний өөр өөрийн өнцгөөс үнэлэлт дүгнэлт өгсөн эх сурвалжийг олж авах ач холбогдолтой.

Түлхүүр үгс: шарилж, үндэсний балет, домгийн сэдэв, эх хэрэглэгдэхүүн, ур чадвар

“Flowers among the weeds” research overview of the national ballet

Barbaatar Giimaа

School of Dance Arts, Mongolian National University of Arts and Culture,

Ulaanbaatar, Mongolia

ORCID: <https://orcid.org/0009-0004-1402-887X>

Corresponding author: baraag0917@gmail.com

Abstract. The stage of development of ballet art in Mongolia began in 1944, and now there are twenty-four national ballet repertoires that reflect the Mongolian national spirit and domestic culture. Currently, there are few research materials on Mongolian ballet art compared to other art fields. In addition, a research review of a national ballet has not yet been published.



Therefore, the books, reviews, and articles written by dance and theater researchers after 1958 need to be reviewed and included in the current study of the history of Mongolian ballet art. In this article, we aim to analyze the research work written about the first national tragic ballet “Flowers among the weeds”. Also, from this article, it is important to get to know the works of researchers who have written about Mongolian ballet art at one place without wasting time, and to find the sources that gave their evaluations from different perspectives.

Keywords: *wormwood, national ballet, the subject of legend, source material, skills*

Оршил

Ч.Нацагдоржийн цомнол, Э.Чойдогийн хөгжим “Шарилжин дундах цэцэг” үндэсний балет нь хүний сэтгэлийн мөн чанар, бусдын жаргалд атаархан хорссоноор өөрөө болон бусдыг ямар эмгэнэлт байдалд хүргэдгийг үзүүлэхийг зорьжээ. Энэхүү балетын цомнол нь домгийн сэдвээр бичсэн бөгөөд үйл явдал, цаг хугацааны хувьд бага хаадын үеийн монгол орны нэгэн нутагт болж буйг харуулдаг.

Гол дүрд ЗХУ-д балетын нарийн мэргэжлээр суралцаж ирсэн монголын анхны жүжигчид тоглосноороо онцлог. “Шарилжин дундах цэцэг” нэг бүлэг, гурван үзэгдэлт балетын зураачаар Л.Гаваа, удирдаачаар Ж.Чулуун, туслах найруулагчаар Г.Батсүх нар ажиллаж, 1965 оны 01 дүгээр сарын 03-ний өдөр үзэгчдийн хүртээл болсон юм. Балетын гол дүр гурав, туслах дүр нэг, эрэгтэй эмэгтэй хорин дөрөв, нийт хорин найман балетын жүжигчид оролцож байжээ. Гол дүр Урангоод С.Шаравдорж (УГЖ), Ю.Цэрмаа (УГЖ), Галтад О.Ганбаатар (АЖ), Д.Баасанхүү, эсрэг дүр Шируунгарьдад Н.Баатар (УГЖ), Ж.Батчулуун, Шируунгарьдын зүүн гарын туслах Зэвтэд Д.Баасанхүү нар анхлан тоглосон.

Балетын утга агуулга нь хайр сэтгэл, атаа хорсол, үзэн ядалт ямар их гай гамшиг учруулдаг, хүний сэтгэлийн мөн чанарыг гол ба туслах дүрээр илэрхийлэн харуулсан билээ. Цомнолыг эхлэл, төгсгөл бүхий гурван үзэгдэлд хувааж, үйл явдлыг хураангуйлан бичсэн. Ингэхдээ гурван үзэгдлийг өглөө, өдөр, орой гэсэн нэг өдөрт болж буй үйл явдлаар илэрхийлсэн. Эхлэл, төгсгөл нь нэгэн тайзнаа дуусдаг балет олонтой байдгийн нэг нь уг балет юм.

Цомнол. Олон жилийн өмнө нас эцэслэсэн хоёр баатрын шарил байх ба нэг нь цэцэг, нөгөө нь шарилж ургасан байна. Урангоо цэцгийн баглаа барин ирж тэртээх өдөр болсон эмгэнэлт явдлыг санаж цэцэг ургасан шарил дээр очсоноор балет эхэлдэг.

Өглөө. Нар мандаж, Урангоо бүсгүй ус авахаар тунгалаг горхины дэргэд эртлэн ирнэ. Тэрбээр төрсөн нутаг, уул усныхаа сайхныг бахдан бүжиглэнэ. Түүний найз бүсгүйчүүд цугларан ирж, залуу насны хөгжөөн цэнгээнтэй бүжгээ хийнэ. Гэнэт морин төвөргөөн сонсогдон, тэдний дэргэд баг цэргийн дарга Шируунгарьд, баруун, зүүн гарын туслах Галт, Зэвт болон цэргүүдийн хамт хүрэлцэн ирнэ. Бүсгүйчүүдтэй мэндчилээд, дайчин эрсийн сүрлэг бүжгийг бүжиллэцгээнэ. Энэ үед Галт Урангоогийн үзэсгэлэн гоо, төлөв даруу зан аашинд сэтгэл татагдана. Урангоод ч Галт таалагдаж, сэтгэл догдолж буйгаа мэдрэв. Тэдний харьцааг ажиж мэдсэн Шируунгарьд байж ядан, хардах, харамлах нь гадаад төрхөд нь илт

харагдана. Зэвт хажуугаас нь Шируунгарьдыг улам өдөөн хатгаж, хардах сэтгэл, хорслыг нь бадрааснаар нэгдүгээр үзэгдэл төгсдөг.

Өдөр. Урангоо бүсгүй ус авахаар дахин горхины дэргэд ирдэг. Гэнэт Шируунгарьд ирж, түүнд хайр сэтгэлээ илчлэн, элдвийн арга хэрэглэн, өвдөг сөгдөн гуйна. Урангоо эс зөвшөөрөхөд, уур хилэн нь бадарч, сүрдүүлж үзнэ. Гэвч бүсгүй зөвшөөрсөнгүй. Бүтэлгүй дурлалаасаа болж ухаан самуурсан Шируунгарьд Галтыг нарт ертөнцөөс зайлуулахаа тангараглан сэлмээ газар шааж, сүртэйеэ зогссоноор тус үзэгдэл төгсдөг.

Орой. Горхины хөвөөнд Шируунгарьд гутарсан сэтгэлдээ дарагдан, Урангоог бодон хайрлан энхрийлэвч бас хардан бачимдана. Энэ үед Галт, Урангоо нар гарч ирнэ. Тэдний царай цаглашгүй ариун хайраар гэрэлтэж, эргэн тойрныг үл анзаарна. Тэднийг харсан Шируунгарьд тэвчээр алдан, дотнын эрэлхэг дайчин Галтыг хурц сэлмээр сүлбэж хорооно. Энэ үед Урангоогийн найз охид цэргүүдийн хамт ирж, болсон явдлыг гайхан балмагдаж, гашуудацгаана. Дайчин цэргүүд Шируунгарьдын хүн чанаргүй хатуу сэтгэлийг жигшин, цаашид түүнийг дагахгүй гэдгээ илтгэн орхиж одно. Гагцхүү түүний дэргэд бялдууч Зэвт л үлдэнэ. Хайрласан бүсгүй, дагуулах дайчингүй ганцаараа үлдсэн Шируунгарьд зам мухардан бачимдаж, хийсэн хэрэгтээ гэмшин, өөрийгөө нарт хорвоогоос хагацуулснаар гуравдугаар үзэгдэл төгсдөг.

Төгсгөл. Урангоо бүсгүй цэцэгт шарил дээрээс аажмаар өндийж, нөгөө шарилын шарилжин дунд цэцэг тавина. Тэрбээр Шируунгарьд хэдийгээр хэрцгий хэрэг үйлдэж, хүн чанаргүй авирласан боловч, амьдралаа үр ашиггүй үрэн таран хийснийг нь өрөвдөн, бүсгүй хүний нинжин сэтгэлээр түүний шарилыг хүндэтгэн, цэцэг тавьснаар энэхүү балет төгсдөг.

Судалгааны арга зүй

Түүвэрлэх, ажиглах, ангилах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, ярилцлагын арга зүйг ашиглав.

Тус судалгааны хүрээнд дараах материалуудыг авч үзсэн болно. Үүнд:

- Ном: Ж.Жав “Монголын балетын урлагийн хөгжил” (1983), “Тавин балетын либретто” (2012), С.Дашдондог “Хөгжим дуурь балет судлал” (2013), “Монголын театрын түүх” (2015), “Соёл урлагийн тайлбар толь V: Бүжиг” (2018), Г.Барбаатар “Бүжиг бол ухааны урлаг” (2020), Т.Туул “Монголын балет” (2022),
- Нийтлэл: Г.Долгорсүрэн “Шарилжин дундах цэцэг”. Үнэн сонин, 1965. №38, Ринчен, Б. “Нэгэн үдшийн хоёр бүжиг”. Хөдөлмөр сонин, 1969. №6 зэрэг шүүмж, Эрдэнэхорлоо, Ж. “Монголын балетын эцэг 80 нас хүрлээ”. Өдрийн шуудан сонин, 2012.10.25. №2 өгүүлэл,
- Магистрын ажил: Д.Алтантуяа “Монголын үндэсний балетын хөгжил, түүний оргил бүтээлүүдийн судалгаа” (2009), Г.Барбаатар “Б.Жамъяндагвын балет дэглэн найруулах уран чадвар (Ж.Мэнд-Амар “Үйлийн гурван толгой” үндэсний балетын жишээгээр)” (2013), Б.Туул “Монголын балетын шүүмжийн судалгааны асуудалд хандах нь” (2018),

- ДБЭТ-ын архив: “Шарилжин дундах цэцэг” балетын хавтас түүхэн баримт зэрэг орно.

Судалгааны үр дүн

Монголын балет, бүжгийн урлагийн эхэн үед Ардын жүжигчин Н.Цэгмид, эрдэмтэн судлаач Б.Ринчен, Ардын багш Г.Долгорсүрэн нар нь монголын бүжгийн урлагийн шүүмжийн суурийг тавьсан бол 1970-1980 онд театр судлаач С.Дашдондог, бүжиг судлаач Ж.Жав нар, 2010 оноос Т.Туул, Ж.Эрдэнэхорлоо нар бүжиг, балет, бүжгэн жүжгийн шүүмж бичиж нийтлүүлсэн нь залуу судлаачдад судалгааны эх хэрэглэгдэхүүн болж байна. Бүжиг судлаач Ж.Эрдэнэхорлоо “Монголын балетын эцэг 80 нас хүрлээ” нийтлэлдээ “Шарилжин дундах цэцэг” балетын талаар дурдсан ба тус нийтлэлээ “Монгол бүжиг судлал” (Эрдэнэхорлоо 2020, 222) номд дахин хэвлэсэн юм. Мөн СУИС-ийн Театрын урлагийн сургуулиас эрхлэн гаргасан “Монголын театрын түүх” (2015) хамтын бүтээлд “Балетын урлаг” гэсэн дэд бүлгийг бичсэн нь судалгааны чухал эх хэрэглэгдэхүүн болж байна. Дээрх номд монголын балетын урлагийн түүхэн хөгжил болон монголд дэглэн найруулсан балетыг он, цагийн дараалалтай, балетын жүжигчдийн талаар нэлээд дэлгэрэнгүй бичсэнээс “Шарилжин дундах цэцэг”-ийн цомнол, жүжгийн утга санаа, дүрийн онцлогийг бичсэн бөгөөд “Тус бүтээл нь хүний өршөөл энэрэл, хүнлэг нинжин сэтгэлийг илэрхийлэхийг зорьжээ” (Долгорсүрэн ба бус 2015, 483) гэж тэмдэглэсэн нь энэхүү балетын зохиол, цомнолын гол санааг илүү тодруулж өгчээ.


Соёл урлагийн их сургуулиас салбарын тайлбар толийг эрхлэн гаргадаг болсон нь судлаач, багш, оюутнуудад судалгааны чухал хэрэглэгдэхүүн болдог ба мэргэжлийн нэр томьёог олон янзаар нэрлэх асуудлыг нэг цэгцэд оруулж өгсөн юм. Энэхүү цуврал тольд

“Шарилжин дундах цэцэг” балетын талаар (Соёл урлагийн их сургууль 2018, 226) оруулсан байдаг.

Түүнчлэн магистрын судалгааны ажлуудад энэ бүтээлийн талаар бичсэн бөгөөд Алтантуяа (2009) үндэсний балетын жагсаалт дотор “Шарилжин дундах цэцэг”-ийг дурдсан; Барбаатар (2013) “Шарилжин дундах цэцэг” балетын дэглэлт найруулгын онцлогийг тодруулж, судлаач Г.Долгорсүрэнгийн бичсэн шүүмжид дүгнэлт хийсэн; Туул (2018) эрдэмтэн зохиолч Б.Ринчений бичсэн шүүмжийг эшлэл болгон оруулж түүндээ дүгнэлт хийжээ.

Түүхэн баримт. “Шарилжин дундах цэцэг” балет нь 1965 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр тайзнаа тоглож, үзэгчдийн хүртээл болсон байна. Судалгааны явцад Улсын Дуурь бүжгийн эрдмийн театр (УДБЭТ)-ын урын сангийн архивд “Шарилжин дундах цэцэг” балетын хавтаст хадгалагдаж буй гар бичмэлээс үзэхэд тус балет 1964 оны 04 дүгээр сард тоглох байж. Балет хойшлохын шалтгаан нь тухайн үеийн Зөвлөлт Холбоот Улсын мэргэжилтэн В.А.Преображенский ирж, Шарль Франсуа Гуногийн “Фауст” дуурийн “Вальпургийн шөнө” бүжгэн үзэгдэл тавьснаас, А.Даргомыжский “Лусын дагина” дуурь шинээр тавих болсноос гэх мэтчилэн олон шалтгааны улмаас бэлтгэл сургуулилт хойшилсон байна. Ийнхүү тус оны 11 дүгээр сараас “Шарилжин дундах цэцэг” балетын бэлтгэл

сургуулилтыг дахин эрчимтэй хийсэн боловч жүжгийн хувцас хэрэглэлийн материалгүй, хөгжмийн партитурын цаасгүйн шалтгаанаар хойшлон, 1964 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 18 цаг 15 минутад УДБЭТ-ын уран сайхны зөвлөлөөр дотоод хяналтад, 1964 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 11 цаг 15 минутад Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Соёлын яамны Уран сайхны зөвлөлийн хяналтад орсноор “Шарилжин дундах цэцэг” балет цаашид олон нийтэд тоглох зөвшөөрлийг авч байжээ. Доорх материалаас үзэхэд, дотоод хяналтад үзүүлээд, дараа өдөр нь Уран сайхны зөвлөлд шалгуулсан нь тус балет засвар, өөрчлөлтгүй байсан болов уу гэж дүгнэгдэж байна (Зураг 1 а, б, в).



Зураг 1 а, б, в. ДБЭТ-ын архив “Шарилжин дундах цэцэг” балетын хавтаст хадгалж буй гар бичмэлээс

“Шарилжин дундах цэцэг” балетын дэглэлт найруулгын онцлогийн талаар: Ардын багш, Монгол Улсын Гавьяат жүжигчин Г.Долгорсүрэн “Шарилжин дундах цэцэг” балетын тухай бичсэн шүүмждээ “Б.Жамьяндагва уг жүжгийг сонгодог бүжгийн арга барилд тулгуурлан, үндэсний бүжгийн хөдөлгөөнөөр баяжуулан найруулсан байна. Ялангуяа уг жүжгийн утга санаа өгүүлэх үйлчлэлийг маш эвтэйхэн товч тодорхой үзүүлсэнд жүжгийн чадал оршиж байна. Хөдөлгөөнийг давталгүй өгүүлэл бүрийг өөр өөр хөдөлгөөнөөр тавьсан, тэрчлэн дараалан гарах үйлдлийг давхардуулахгүй эвийг нь олж чадсан нь залуу балетмейстерийн амжилт гэж үзүүштэй” (Долгорсүрэн 1965, №38) хэмээн бичсэн байна. Энэ шүүмждээ тэрбээр балетын гол дүрүүдийн хоорондын зөрчил тэмцлийг илэрхийлсэн хөдөлгөөн, дүр бүрийн зан төрхийг илүү тодотгон бичсэн нь бусад шүүмжид тусгагдаагүй чухал баримт болж байна. Мөн “Залуу балетмейстер цаашид бодууштай зүйл гэвэл сонгодог бүжгийн үндсэн хэллэг дээр үндэснийхээ бүжгийн хөдөлгөөнөөс аль болохоор түлхүү авч хэрэглэхийг бодох нь зүйтэй” (Долгорсүрэн 1965, №38) хэмээн цаашид үндэсний балет дэглэн найруулахад нь чухал хөдөлгөөний сан эрэл хайгуулын үндсийг хэлж өгсөн байдаг. Энэхүү шүүмж нь дан ганц балетмейстерийн ур чадвар, дэглэлт найруулга дээр үнэлэлт дүгнэлт өгсөнгүй хөгжим, хөгжмийн зохиолч, балетын жүжигчдийн мэргэжлийн ур чадварт, мөн

судлаачийн өнцгөөс харсан зөвлөмжийг тусгасан байна. Тухайлбал, “Хөгжмийн зохиолч Э.Чойдогийн хөгжим уг жүжгийн утга санааг тод томруун тусгаж чадсан байна. Хөгжмийн хэлээр сайн муу талын дүрийг тодорхой гаргажээ. Ялангуяа найрал хөгжмийн найруулга аятай сайн болсон байна. Гэхдээ үндэсний аялгуугаар баяжуулах, эгшиг хөгийн зохицлыг давшингуй болгох талаар хөгжмийн зохиолч Э.Чойдог анхаарах нь зүйтэй” (Долгорсүрэн 1965, №38) хэмээн тэмдэглэсэн байна. Төрийн шагналт, УГЗ Э.Чойдог бол манай бүжиг, балетын урлагт үнэлж баршгүй гавьяатай хөгжмийн нэрт зохиолчдын нэг юм. Тэрбээр үндэсний таван балетын хөгжим бичсэн нь өнөөдөр судалгааны чухал баримт, эх хэрэглэгдэхүүн болжээ.

Эрдэмтэн зохиолч Б.Ринчен “Нэгэн үдшийн хоёр бүжиг” шүүмждээ “Хөгжим, бүжгийн уялдаа муу байснаас эмэгтэй бүжигчдийн хөдөлгөөн “чамлалттай” байж. Бүжгийг үзэхэд хөгжим нь бүжигт тун ч учиртай гэдгийг баталж байгаа юм байна. Хөгжимдөө татагдаад балетмейстер нь зарим санаа байдлыг бүжиглэх хөдөлгөөнөөр гаргахын аргагүй болж ялангуяа эмэгтэйчүүдийн бүжиглэх зарим нэг хөдөлгөөн нь түүнээс болж чамлалттай харагдаж байна” (Ринчен 1969, №6) гэж бусад шүүмжид дурдаагүй балетын дэглэлт найруулга, хөгжим, тайз заслын талаар хурцаар шүүмжилсэн нь тухайн үеийн хөгжмийн зохиолч, балетмейстер, залуу жүжигчдийг цаашид уран бүтээл хийхэд нь улам хурцалж, чадавхжуулж өгсөн болов уу.

“Шарилжин дундах цэцэг” балетын жүжигчдийн ур чадварын талаар: Ж.Жавын “Монголын балетын урлагийн хөгжил” номд 1950-1983 онд гарсан балетын шүүмж, өгүүлэл, сэтгэгдэл зэргийг эмхэтгэн оруулсан нь бүжиг, балет судлалд үнэ цэнтэй бүтээл гэж үздэг. Тус номын 33-35 болон 196-197 нүүрт “Шарилжин дундах цэцэг” балетын цомнол, балетмейстер, балетын жүжигчдийн мэргэжлийн ур чадвар талаас нь бичсэн ба “О.Ганбаатар, С.Шаравдорж нар ч гэсэн жүжигчний уран чадварыг эзэмших, дүрийн сэтгэлийн орчлонг нээн гаргах талаар нэлээд чадваржиж байгаа нь энэ жүжгээс харагдав” мөн “Шаравдоржийн жүжиглэхийн гол шугам нь дотоод сэтгэлийн хөдлөлөө гадаад төрх намба, ялангуяа хөгжил баясал, гуниг гутралын илэрхийллээр тодорхой хэлж чаддаг нүүрний жүжиглэлт маш сайтай жүжигчин юм” (Жав 1983, 197) хэмээн балетын жүжигчдийн



*Зураг 2. Хоёрдугаар үзэгдэл: Урангоод
Д.Алтантуяа (Ася), Шируүнгарьдад
Ж.Батчулуун*

дүрд хувирах, утга санаагаа илэрхийлж буй хөдөлгөөнийг гүйцэтгэх ур чадварт үнэлэлт дүгнэлт өгч байжээ. Театр судлаач С.Дашдондог “Энэ цомнол зохиол цомхон бөгөөд бүжгэн жүжигт нийцэж өгснөөрөө шинэлэг бүтээл байлаа” (Дашдондог 2013, 69) гэж тус балетын цомнолыг дүгнэсэн байдаг. Тэрбээр Шируүнгарьдын дүрийг онцлон тэмдэглэхдээ: “Энэ дүрийн хоёр өөр шугам, нэг бол түүний дээрэнгүй зан, атаач, алж устгах, хэрцгий авирыг илүү тод гарган үзүүлэх, эс бөгөөс хийсэн хэрэгтээ гэмшин

өөрөө өөрийгөө хөнөөж байгаа их зоригийг товойлгон харуулах хоёр шугамын сүүлчийг нь бүжигчин Н.Баатар сонгож авсан байна” (Дашдондог 2013, 70) гэжээ. Ширүүнгарьдын дүрд анхлан бүжиглэсэн Н.Баатар нь дүрийнхээ зоримог байдал, түргэн хурц зан аашийг товойлгон харуулж жүжиглэж чадсан байдаг (Зураг 2).



*Зураг 3. Нэгдүгээр үзэгдлийн найз охид
Зүүнээс: А.Навчаа, Ж.Цэцэгмаа,
Г.Дашидулам, Ю.Цэрмаа*

тусгасан чимэглэл төдийгүй монгол охидын үнэнхүү хөөрхөн зан ааль, цэргүүдийн дайчин омог зоригийг нь тусгасан тодруулга болсон байдаг” (Туул 2022, 32) хэмээн бүжгийн хөдөлгөөн талаас нь нухацтай тэмдэглэсэн байна (Зураг 3).

Балетмейстер Б.Жамъяндагвыг сургууль төгсөж ирэхэд нь хөгжмийн зохиолч Э.Чойдог, хормейстер Л.Даваахүү нарын хамт Ховд аймгийн Хөгжимт драмын театр (ХДТ)-т багшлуулахаар бүтэн жилийн хугацаанд томилон явуулсан байдаг. Энэ хугацаанд тэрбээр Э.Чойдогтой хамтарч ардын дууны аян дээр арван гурван бүжиг дэглэн найруулж, театрын нээлтэд тоглуулж. Түүнчлэн Ховд аймгийн ХДТ-т ажиллах хугацаандаа ардын урлагаа илүү гүнзгийрүүлэн судалсан юм. Тэрбээр хэлэхдээ “Ховдод очиж жил шахуу судалгаа хийсний хүчинд би ардын урлагийг сайн мэддэг болсон” (Жамъяндагва 2020) гэж билээ. Ийнхүү ардын урлаг тэр дундаа бий биелгээ сурч, судалсны үндсэн дээр цаашид үндэсний балет дэглэн найруулах суурь судалгаа болж өгсөн гэх үндэслэлтэй. Мөн “Охидын баясал”, “Залуусын золбоо” зэрэг бүжгийг судалгаандаа тулгуурлан дэглэн найруулсан нь дээрх балетыг найруулах нэгэн алхам байж. Б.Жамъяндагва цаашид улам судалж, суралцаар Ж.Чулуун “Уран хас” (1973), Э.Чойдог “Мөнгөн залаа” (1979), Ж.Мэнд-Амар “Үйлийн гурван толгой” (1987) зэрэг нийт арван дөрвөн үндэсний балет дэглэн найруулсан балетмейстер юм.

Хэлэлцүүлэг

“Шарилжин дундах цэцэг” үндэсний балет нь манай улсын балетын жүжигчдийг олон улсад таниулахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Учир нь бүжиг судлаач Т.Туул хэлэхдээ “1968 онд Варнад болсон олон улсын балетын жүжигчдийн уралдаанд Б.Жамъяндагва багш, О.Ганбаатар бид гурав очиж оролцсон. Уралдааны II шатанд заавал орчин үеийн бүжгээр оролцох ёстой байсан. Тухайн үед бид орчин үеийн бүжиг гэж мэдэхгүй учраас Э.Чойдог “Шарилжин дундах цэцэг” балетын

“Хослол”-ыг бүжиглэсэн. Тэрнээс хойш багш Москва, японы олон улсын балетын жүжигчдийн уралдаанд жүжигчдээ байнга авч явж оролцдог болсон. Варнагийн уралдаанд бол олон удаа оролцсон” (Туул 2013) хэмээн дурсан ярилцаж байв.

Э.Чойдогийн “Шарилжин дундах цэцэг” балет нь хөгжмийн зохиолч, балетмейстер, тайзны зураач, удирдаач, балетын жүжигчдийн хамтын бүтээлч сэтгэлгээгээр бүтсэн бөгөөд 1965 оноос хойш эдүгээ 59 дахь жилдээ УДБЭТ – ын тайзнаа тоглож байна.

Дүгнэлт

Ч.Нацагдоржийн зохиол, Э.Чойдогийн хөгжим тус үндэсний балет нь хүний сэтгэлийн мөн чанарыг харуулсан эмгэнэлт бүтээл бөгөөд бусдын жаргалд атаархан хорсох нь хүнийг эцэст нь ямар эмгэнэлт байдалд оруулж буйг тус балетаас үзэж болно.

1965 онд анх тайзнаа тоглосон энэхүү бүтээлийг бакалаврын дипломын хоёр ажил, урлаг судлалын ухааны магистрын зэрэг горилсон гурван бүтээлд түүхэн болон дэглэлт найруулга талаас нь судлан тодруулсан байна. Мөн эрдэмтэн, судлаач Б.Ринчен, Г.Долгорсүрэн, Ж.Жав, С.Дашдондог, Т.Туул, Ж.Эрдэнэхорлоо нар “Шарилжин дундах цэцэг” үндэсний балетыг өөр өөрийн өнцгөөс судалж тайлбарлахдаа цомнол, дэглэлт найруулга, балетын жүжигчний ур чадвар талаас нь бичиж, судалгааны эргэлтэд оруулжээ. “Шарилжин дундах цэцэг” үндэсний балетын судалсан байдлыг тодруулснаар дараах дүгнэлтэд хүрч байна.

1. Балет бол урлагийн олон төрлийг өөртөө цогцлоосноор нэг бүтээлийг гаргадаг синтез урлаг юм. Иймд тус балетын хөгжим, тайз засал, хувцасны онцлогийг цаашид нарийвчлан системтэйгээр судлах, өөрөөр хэлбэл, үндэсний хувцасны хэв шинжийг “Шарилжин дундах цэцэг” балетад хэрхэн шинэчлэл хийж оруулсан талаар судлах.
2. Дэглэлт найруулга, дүрийг илэрхийлж буй сэдэв хөдөлгөөн, зохиомжийн талаар нарийвчилсан судалгаа ховор учраас цаашид дэлгэрүүлэн судлах.
3. Балетад үндэсний онцлогийг хэрхэн тусгасан, юу нь шинэлэг учраас УДБЭТ-ын урын санд өнөөдрийг хүртэл тоглож буйг, тавин есөн жил тоглохдоо балетын дэглэлт найруулга, жүжигчдийн гүйцэтгэх чадвар ямар өөрчлөлт орсныг нээн илрүүлэх.
4. “Шарилжин дундах цэцэг” балетад дүр бүтээснээр жүжигчний ур чадварт хэрхэн нөлөөлөх ач холбогдлын талаар судлах.
5. Дээрх судалгаа бүрд цомнол, зохиол нь домгийн сэдэвтэй гэх боловч ямар утга агуулгатай домог вэ? гэдгийг хараахан тэмдэглээгүй байна. Харин Ж.Жавын бичсэн номд “Говь-Алтай, Баянхонгор зэрэг манай баруун аймгуудад дэлгэрсэн ардын богинохон домгийн нэр” гэж дурдсанаас өөр зүйлгүй тул цаашид зохиол, цомнол бичсэн домгийг тодорхой болгож судлах нь зүйтэй гэж дүгнэж байна.

Ашигласан материалын жагсаалт

- Барбаатар, Гиймаа. 2020. *Бүжиг бол ухааны урлаг*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Дашдондог, Самдан. 2013. *Хөгжим дуурь балет судлал*. Улаанбаатар: Хүслийн өнгө.
- Жав, Жамсран. 1983. *Монголын балетын урлагийн хөгжил*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Соёл урлагийн их сургууль. 2018. *Соёл урлагийн тайлбар толь, Боть V: Бүжиг*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
- Театрын урлагийн сургууль. 2015. *Монголын театрын түүх*, Ред. Долгорсүрэн, Ж., Алтанцэцэг, Ч. ба бус. Улаанбаатар: Бемби сан.
- Туул, Т. 2022. *Монголын балет*. Улаанбаатар: Жиком Пресс.
- Улсын Дуурь бүжгийн эрдмийн театр. 2012. *Тавин балетын либретто*. Ред. Жамъяндагва, Б. Улаанбаатар: Хүслийн өнгө.

Шүүмж, нийтлэл

- Долгорсүрэн, Г. 1965. “Шарилжин дундах цэцэг бүжгэн жүжиг.” *Үнэн сонин*, 1965, №38.
- Ринчен, Б. 1969. “Нэгэн үдшийн хоёр бүжиг.” *Хөдөлмөр сонин*, 1969, №6.
- Эрдэнэхорлоо, Ж. “Монголын балетын эцэг 80 нас хүрлээ.” *Өдрийн шуудан сонин*, 2012.10.25, №2.

Магистрын зэрэг горилсон судалгааны ажил

- Алтантуяа, Дорж. 2009. “Монголын үндэсний балетын хөгжил, түүний оргил бүтээлүүдийн судалгаа.” Магистрын судалгааны ажил., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.
- Барбаатар, Гиймаа. 2013. “Б.Жамъяндагвын балет дэглэн найруулах уран чадвар (Ж.Мэнд-Амар “Үйлийн гурван толгой” үндэсний балетын жишээгээр).” Магистрын судалгааны ажил., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.
- Туул, Баяр. 2018. “Монголын балетын шүүмжийн судалгааны асуудалд хандах нь.” Магистрын ажил., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.

Ярилцлага

- Балжиннямын Жамъяндагватай хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 12-р байр, 10 тоот, 2020.06.03.
- Түндэврэгзэний Туултай хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: Хөгжим бүжгийн коллежийн хичээлийн танхим, 2013.04.25.

Архивын баримт, материал

- ДБЭТ-ын архив. *Шарилжин дундах цэцэг*. Үндэсний балетын хавтас. Улаанбаатар.